

**АРД ДААТГАЛ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ
ЗАРЛАН ХУРАЛДУУЛАХ ЖУРАМ**

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ



1.1. Энэхүү журмаар Хувьцаа эзэмшигчдийн хурал (цаашид ХЭХ гэх)-ын эрх мэдэл, хурлыг зарлах, хурлын бэлтгэлийг хангах, хуралдах, зохион байгуулах ажлыг гүйцэтгэх багийг сонгох, түүнчлэн бусад холбогдох асуудлуудыг зохицуулна. ХЭХ нь компанийн удирдах дээд байгууллага болно.

1.2. ХЭХ дараах шийдвэр гаргаж болно:

1.2.1. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг хувьцаа эзэмшигчдийн биечилсэн оролцоотой эсвэл тэдний төлөөлөлтэйгөөр хуралдуулах, хурлаар хэлэлцэх асуудлыг товлох, шаардлагатай асуудлын талаарх шийдвэрийг саналын хуудсаар эсвэл саналын хуудсаар биш замаар санал хурааж гаргах, эсвэл

1.2.2. Саналыг эчнээ хэлбэрээр (хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулахгүйгээр) саналын хуудсаар авах.

1.3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг ТУЗ (байхгүй бол гүйцэтгэх удирдлага) санхүүгийн жил дууссанаас хойш дөрвөн (4) сарын дотор буюу 05 дугаар сарын 01-ээс өмнө зарлан хуралдуулна.

ХОЁР. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ХУРЛЫН БҮРЭН ЭРХ

2.1 ХЭХ-ын бүрэн эрхэнд дараах асуудлууд орно:

2.1.1. компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах болон шинэчилсэн найруулгыг батлах

2.1.2. компанийг өөрчлөн байгуулах

2.1.3. компанийг татан буулгах, татан буулгах комиссыг томилох

2.1.4. Хэрэв компани нь ТУЗ-гүй бол татан буулгах балансын завсрын болон эцсийн балансыг батлах,

2.1.5. ТУЗ-ийн гишүүдийн тоог тогтоох, ТУЗ-ийн гишүүдийг сонгох эсвэл хугацаанаас нь өмнө огцруулах.

2.1.7. ТУЗ-өөс бэлтгэсэн компанийн жилийн үйл ажиллагаа болон санхүүгийн тайланг хянан батлах,

2.1.8. ТУЗ болон ХЭХ-ын журмыг батлах

2.1.9 Компанийн нэгж хувьцааны нэрлэсэн үнийг нэмэгдүүлэх эсвэл бууруулах, нэмж гаргах хувьцааны тоог тодорхойлох, компанийн гаргасан хувьцаа эргүүлэн худалдан авах эсвэл хүчингүй болгох замаар дүрмийн санд нэмэлт өөрчлөлт оруулах,

- 2.1.10. Компанийн өрийг хувьцаагаар солих асуудлыг шийдэх,
- 2.1.11. Зөвшөөрөгдсөн хувьцааны тоо, нэрлэсэн үнэ, төрлийг тогтоох болон энэ төрлийн хувьцаатай холбогдол бүхий эрхүүдийг тодорхойлох,
- 2.1.12. Хувьцааг хуваах, нэгтгэх,
- 2.1.13. Сонирхлын зөрчилтгэй болон их хэмжээний хэлцлийг байгуулах эсэхийг хэлэлцэж, гэрээг байгуулах эрхийг гүйцэтгэх удирдлагад олгох,
- 2.1.14. ТУЗ-д хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хуралдуулах хүсэлт тавьсан ч ТУЗ үүнийг хэрэгжүүлээгүй эсвэл татгалзсан тохиолдолд тухайн ээлжит бус хурлыг өөрийн санаачилгаар хуралдуулсан санал гаргагчийн зардлыг нөхөн төлөх асуудлыг баталгаажуулах,
- 2.1.15. Компанийн үндсэн үйл ажиллагаа, энэ үйл ажиллагаанд оруулсан өөрчлөлт ямар үр дүнтэй байсан, компанийн удирдах албаны хүмүүст олгосон шагнал урамшуулал цалингийн хэмжээ, тайлангийн хугацаанд компанийн менежменттэй холбогдон гарсан зардал зэргийг хамруулсан компанийн бүтэц зохион байгуулалт, хөрөнгө; бизнесийн үйл ажиллагааны тухай ТУЗ-өөс бэлтгэн оруулсан тайлан илтгэлийг хэлэлцэн баталгаажуулах,
- 2.1.16. “компанийн нэгдэл”, “хуулийн этгээдийн нэгдлийн гишүүн”, “зэргэлдээ компаниуд”-д оролцох асуудлыг баталжуулах,
- 2.1.17. ХЭХ-ын эрх мэдлийн хүрээний асуудлыг гүйцэтгэх удирдлага төлөөлөн хэрэгжүүлэхгүй.

ГУРАВ. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛД САНАЛ ОРУУЛАХ

- 3.1. Саналын эрх бүхий хувьцаа эзэмшигч хурлын хэлэлцэх асуудалд санал оруулж болно. Хурлын хэлэлцэх асуудалд санал оруулахад шаардагдах хувьцаа эзэмшигчдийн эзэмшиж байгаа саналын тоог тухайн санал гаргах өдрөөр тогтооно. Саналыг санхүүтийн жил дууссанаас хойш хуанлийн 60 өдрийн дотор гаргана.
- 3.2. Хувьцаа эзэмшигчийн гаргах санал нь ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэх хэрэв компани ТУЗ-гүй бол мөн тоологын комисст нэр дэвшүүлэх зэрэг асуудлуудыг багтааж болно.
- 3.3. Компанийн удирдах албан тушаалд нэр дэвшүүлэх хүний тоо нь сонгогдох нийт хүний тооноос хоёр дахин их байна.
- 3.4. Хувьцаа эзэмшигчийн дэвшүүлэх санал нь тухайн саналыг хурлын хэлэлцэх асуудалд шууд тусгахуйцаар найруулан бичигдсэн байна. Мөн гаргах шийдвэрийн төслийг агуулсан байж болно.
- 3.5. ХЭХ-ын хэлэлцэх асуудалд дэвшүүлэх саналыг дараах хэлбэрээр хүргүүлж болно:

3.5.1. Баталгаат шуудангаар дараах хаягаар явуулах:

_____ -ны анхааралд _____ (тухайн саналыг хүлээн авах эрх бүхий хүний нэр, албан тушаалыг бичнэ);

3.5.2. Биечлэн хүргэх, саналыг хүлээн авсан хүний гарын үсэг бүхий нотолгоог авна. (*ТҮЗ-ийн нарийн бичгийн дарга эсвэл компанийд хаягласан бичиг баримтыг хүлээн авах эрх бүхий хүн*)

3.6. ХЭХ-ын хэлэлцэх асуудалд санал оруулах болон компанийн удирдах албан тушаалд нэр дэвшүүлэхтэй холбогдсон саналыг хүргүүлэхдээ хувьцаа эзэмшигч нь гарын үсгээ зурна.

Хэрэв тухайн саналд хувьцаа эзэмшигчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч гарын үсэг зурсан бол хуулийн заалтын дагуу хийгдсэн итгэмжлэлийг (эсвэл итгэмжлэлийн баталгаажуулсан хувь) хавсаргана.

3.7. ХЭХ-ын хэлэлцэх асуудал болон нэр дэвшүүлэх саналыг бичгээр үйлдэх ба дараах асуудлыг тусгана:

3.7.1. Санал дэвшүүлж байгаа хувьцаа эзэмшигчийн нэр

3.7.2. Эзэмшиж байгаа хувьцааны тоо ба төрөл

3.7.3. Дэвшүүлж байгаа саналын тухай болон тухайн саналыг дэвшүүлэх болсон шалтгаан

3.8. Компанийн удирдлагад нэр дэвшүүлэх тохиолдолд дараах мэдээллийг оруулна:

3.8.1. Нэр дэвшүүлж байгаа хүний овог, нэр

3.8.2. Нэр дэвшүүлж байгаа хүн нь компанийн хувьцаа эзэмшигч бол түүний эзэмшиж байгаа хувьцааны тоо, төрөл

3.8.3. Нэр дэвшүүлэх болсон шалтгаан

3.8.4. Чухам ямар албан тушаалд нэр дэвшүүлж байгаа

3.8.5. Тухайн нэр дэшигчтэй холбоотой бусад мэдээллийн материал

3.9. Хараат бус гишүүнд нэр дэвшүүлж байгаа бол нэр дэвшүүлж байгаа этгээд нь хуульд заасан хараат бус гишүүний шаардлагыг хангаж байгаа талаар саналдаа тусгах

3.10. ТҮЗ тухайн саналыг хянаж, саналыг хүлээн авснаас хойш ажлын арван таван өдөрт багтаан саналыг хүлээн авч байгаа эсвэл татгалзаж байгаа талаар шийдвэр гаргана. ТҮЗ нь хувьцаа эзэмшигчийн хэлэлцэх асуудлын талаар гаргасан санал, шийдвэрийн төслийн томъёоллыг өөрчлөхгүй.

3.11. ТҮЗ тухайн саналыг хэлэлцэх асуудалд оруулах, эсвэл нэр дэвшүүлж байгаа хүнийг компанийн удирдлагад нэр дэшигчдийн жагсаалтад оруулах эсэх талаарх ТҮЗ-ын шийдвэрийг тухайн саналыг дэвшүүлсэн хувьцаа эзэмшигчид шийдвэр гарснаас хойш ажлын гурван өдөрт багтаан, татгалзсан бол шалтгааны хамт мэдэгдэнэ.

3.12. ТҮЗ дараах нөхцөлөөс бусад тохиолдолд хувьцаа эзэмшигчийн хэлэлцэх асуудалд оруулах санал болон нэр дэвшүүлж байгаа хүний нэр дэшигчдийн жагсаалтад оруулна:

3.12.1. Журмын 3.1-д заасан хугацаанд хувьцаа эзэмшигч өөрийн саналыг хүргүүлээгүй бол

3.12.2. Журмын 3.1-д заасан шаардлагатай тооны хувьцааг санал гаргагч нь эзэмшээгүй бол,

3.12.3. Журмын 3.6, 3.7 болон 3.8-д заасан шаардлагыг хангагүй бол,

3.12.4. Хэлэлцэх асуудалд оруулахаар дэвшүүлж байгаа санал нь ХЭХ-ын эрх мэдлийн хүрээнд хамаarahгүй, эсвэл Хуулийн шаардлагыг хангахгүй бол.

3.13. ХЭХ-ын хэлэлцэх асуудалд оруулах хувьцаа эзэмшигчийн санал дээр нэмж, эсвэл хувьцаа эзэмшигчдээс санал огт ирээгүй, эсвэл компанийн удирдах байгууллагад нэр дэвшүүлж байгаа хүний too нийт сонгогдох хүний тоонд хүрэхгүй байгаа бол ТУЗ нь өөрийн үзэмжээр хурлаар хэлэлцэх асуудал нэмж санал оруулах эсвэл нэмж нэр дэвшүүлэх эрхтэй болно.

3.14. ХЭХ-ын хэлэлцэх асуудалд дараах асуудлууд орно:

3.14.1. ТУЗ-ийн гишүүдийг сонгох, бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох шийдвэр

3.14.2. Компанийн жилийн ажлын тайлан, жилийн санхүүгийн тайланг баталгаажуулах ба үүнд компанийн ашиг, алдагдалтай (ашиг, алдагдал дансаар) холбоо бүхий асуудал хамрагдах ба гэхдээ үүгээр хязгаарлагдахгүй байж болно.

3.14.3 Компаниас үнэт цаас гаргах шийдвэр

3.14.4 хуулийн байгууллага, олон нийтийн байгууллага, сангүүдтай компани хэрхэн хамтран ажиллах талаар гаргах шийдвэр

3.14.5 хараат охин компани байгуулах шийдвэр

3.14.6 сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрөл олгох, уг хэлцлийг хийх журам

3.14.7 Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах, эсхул дүрмийн шинэчилсэн найруулга

ДӨРӨВ. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

4.1. ХЭХ-ын бэлтгэлийг хангах явцад ТУЗ дараах асуудлуудыг товлон тогтооно:

4.1.1. ХЭХ-ыг хуралдуулах хэлбэр (хувьцаа эзэмшигчдийг болон түүний итгэмжлэгдсэн төлөөлөгчийг хуралд биечлэн оролцуулах замаар зохион байгуулна),

4.1.2. ХЭХ хуралдах өдөр, газар, цаг бэлэн болсон саналын хуудсыг хүчинтэй байх хугацаанд нь хүргүүлэх шуудангийн хаяг,

4.1.3. Хэрэв компани нь хувьцаат компани бол бүртгэлийн өдөр,

4.1.4. ХЭХ-аар хэлэлцэх асуудал

4.1.5. ХЭХ-ын мэдээллийг хувьцаа эзэмшигчдэд хүргэх журам,

4.1.6. ХЭХ-ын бэлтгэлийн явцад хувьцаа эзэмшигчдэд хүргэх мэдээлэл, материалын жагсаалт болон тухайн мэдээллийг хүргүүлэх журам,

4.1.7. Саналыг саналын хуудсаар авах бол саналын хуудасны хэлбэр, агуулга,

4.1.8. Хэлэлцэх асуудал тус бүрээр санал өгөх эрх бүхий энгийн болон давуу
эрхийн хувьцааны ангилал

4.1.9. Хурал удирдах дарга,

4.1.10. Тооллогын комиссын дарга болон гишүүд

4.2. Хувьцаа эзэмшигчдийн жагсаалтыг компанийн үнэт цаас эзэмшигчдийн бүртгэлийг хөтлөх эрх бүхий этгээд бэлтгэх ба ТУЗ-ийн товлосон бүртгэлийн өдрөөр тасалбар болгон жагсаалтыг гаргаж, бэлтгэсэн жагсаалтыг хурлыг зохион байгуулагчид өгнө.

4.3. Хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтад дараах зүйлийг оруулна:

4.2.1. Хувьцаа эзэмшигчдийн овог, нэр

4.2.2. Хувьцаа эзэмшигч бүрийн хаяг

4.2.3. Хувьцаа эзэмшигч бүрийн эзэмшиж байгаа хувьцааны тоо, төрөл

4.2.4. Бүртгэлийн өдрийг ТУЗ товлох ба энэ өдөр нь тухайн хурал хуралдахаас 45-аас доошгүй хоногийн өмнө байна. ХК-ий хувьд бүртгэлийн өдрийг хурал зарлагч этгээд Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон журмын дагуу тогтооно.

4.5. Хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг компанийн байранд (жагсаалтыг танилцуулах үүрэг бүхий хүннэгж) компанийн нийт хувьцааны 10-аас доогүй хувийг эзэмшигчид хүсэлтийн нь дагуу танилцуулна. Жагсаалтад байгаа хүмүүс хэн болох тухай мэдээлэл болон тэдний шуудангийн хаягийг тухайн хүний зөвшөөрөлгүйгээр танилцуулж үл болно.

4.6. Хэрэв жагсаалтад орсон хувьцаа эзэмшигч нь бүртгүүлсэний дараа, ХЭХ хуралдах өдрөөс өмнө хувьцаагаа шилжүүлсэн бол:

4.6.1. Шинэ хувьцаа эзэмшигчид итгэмжлэл гаргаж өгнө:

4.6.2. Шинэ хувьцаа эзэмшигчийн зааврын дагуу ХЭХ-д санал өгнө.

4.7. ХЭХ-д оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигч нь бүртгэлийн өдрийн дараа шилжүүлсэн хувьцааныхаа хувьд итгэмжлэл гаргасан бол тухайн хувьцааг шинээр эзэмшигч нь хувьцаагаа бүртгүүлж, саналын хуудас авах ба ХЭХ-д оролцох эрхтэй.

4.8. Хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах үед ямар нэг алдааны улмаас хувьцаа эзэмшигчдийн жагсаалтад ороогүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал болохоос өмнө хувьцаа эзэмшигчдийн жагсаалтад өөрчлөлт оруулж болно.

4.9. Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зарыг хүргэх харилцааг СЗХ-оос тогтоосон журмын дагуу зохицуулна.

4.10. Хувьцаа нэмж гаргах шийдвэр гаргах үед хувьцаа эзэмшигчдийн бүртгэлээр нэмж гаргасан хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах эрхтэй хувьцаа эзэмшигчдэд хувьцаа эзэмшигчдийн хурлын зарыг түгээдэг журмын дагуу энэхүү эрхээ хэрэгжүүлэх боломжтойг мэдэгдэх ба энэхүү мэдэгдэлд гаргах гэж байгаа хувьцааны тоо, үнэ,

хувьцаа эзэмшигч бүрийн худалдан авч болох хувьцааны тоо, нэмэлт хувьцааг худалдан авах нөхцөл зэрэг хамрагдах ба холбогдох мэдээллийг баталгаат шуудан буюу тухайн мэдээллийг нийтэлсэн материалаас авна.

4.11. ХЭХ-ыг хурлын зарыг хүргэсэн өдрөөс болон ХЭХ-ын бэлтгэлийн явцад ХЭХ-д оролцох эрх бүхий хүмүүст хүргүүлэх мэдээлэл болон материалд дараах зүйлүүд орно:

4.11.1. Жилийн ажлын тайлан болон санхүүгийн тайлан, хөндлөнгийн аудиторын тайлангийн хамт,

4.11.2. ТУЗ болон гүйцэтгэх удирдлагад (компанид ТУЗ байхгүй бол) нэр дэвшигчийн тухай мэдээлэл, тэдгээр нэр дэвшигчдэд олгох цалин\урамшууллын тухай мэдээлэл, түүнчлэн нэр дэвшигчийн тухайн сонгуульд өрсөлдөхийг зөвшөөрч байгаа тухай бичгэн зөвшөөрөлтэй холбогдсон материал, хэрэв байгаа бол,

4.11.3. Тайлангийн хугацаанд компаниас байгуулсан сонирхлын зөрчилтэй хэлцлүүдийн жагсаалт болон тэдгээр хэлцлийг Компанийн тухай хуулийн арванхоёрдугаар бүлэгт заасан журмын дагуу хийсэн эсэх тухай аудитын байгууллагын дүгнэлт,

4.11.4. Компанийн дүрэмд оруулах нэмэлт өөрчлөлт эсвэл шинэчилсэн найруулгын төсөл, мөн компанийн журамд оруулах өөрчлөлтийн төсөл,

4.11.5. Компанийн нэгдмэл сонирхол бүхий этгээдүүдийн нэrsийн жагсаалт, тэдний эзэмшиж байгаа хувьцааны тоо, төрөл,

4.11.6. ХЭХ-аас гарах шийдвэрийн төсөл болон бусад холбогдох материал.

4.12. Хурлаар компанийн хувьцааг эргүүлэн худалдаж авах шаардлага тавих эрхтэй холбогдсон асуудлыг хөндөх бол ХЭХ-ын бэлтгэл ажлын явцад ХЭХ-д оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдэд тараах нэмэлт мэдээлэл буюу материалд дараах зүйлүүдийг оруулна:

4.12.1. Хувьцаа эзэмшигч хувьцааг эргүүлэн худалдан авах шаардлагыг эрхийнхээ дагуу тавих үеийн тухайн хувьцааны зах зээлийн үнийн талаар хөндлөнгийн үнэлгээчийн дүгнэлт:

4.12.2. Тайлангийн хугацааны компанийн хөрөнгийн цэвэр үнэлгээний тооцоо:

4.12.3. Хувьцааг эргүүлэн худалдан авах тухай болон эргүүлэн худалдан авах үнийн талаар шийдвэр гаргасан ТУЗ-ийн хурлын тэмдэглэл (эсвэл холбогдох хэсэг):

4.13. Хурлаар компанийг өөрчлөн байгуулах асуудлыг хэлэлцэх бол ХЭХ-д оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигч нь дараах мэдээлэл, материалыг хүлээн авна:

4.13.1. Өөрчлөн байгуулах тухай танилцуулга боон өөрчлөн байгуулах нөхцөл:

4.13.2. Өөрчлөн байгуулалтад оролцох бүх компанийн ХЭХ-ын өмнөх гурван жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан эсвэл компани гурваас цөөн жил үйл ажиллагаа явуулж байгаа бол үйл ажиллагаа явуулж ирсэн жил бүрийн тайлангууд:

4.13.3. Өөрчлөн байгуулахад оролцож байгаа бүх компанийн ХЭХ-ын өмнөх улирлын санхүүгийн тайлан:

4.13.4. Өөрчлөн байгуулснаар үүсэх бүх компаниудын үүсгэн байгуулах тухай баримт бичгийн төслүүд:

4.13.5. Нэгтгэх (нийлүүлэх) тухай байгуулсан хэлэлцээрийн хувь болон хуваах эсвэл өөрчлөх тухай гарсан шийдвэрийн хувь:

4.14. ХЭХ-д бэлтгэх явцад тухайн хуралд оролцох эрх бүхий хүмүүст холбогдох мэдээлэл, материалтай ХЭХ-аас наад зах нь 30 өдрийн өмнө танилцах боломжоор хангах ба хэрэв хурлаар компанийг өөрчлөн байгуулах асуудал хэлэлцэх бол ХЭХ-аас наад зах нь 20 өдрийн өмнө танилцуулна.

4.15. ХЭХ-ын бэлтгэлийн хугацаанд, ХЭХ-д оролцох эрх бүхий хүмүүс хурлын холбогдол бүхий мэдээлэл болон материалтай гүйцэтгэх захирлын алба эсвэл ХЭХ-ыг хуралдуулах зард дурдсан хаяг бүхий газарт очиж танилцана. Эдгээр мэдээлэл, материалыг мөн ХЭХ-ын үеэр хуралд оролцогсод авч болно.

4.16. Компани нь ХЭХ-д оролцох эрх бүхий этгээдийн хүсэлтийн дагуу дээр дурдсан баримт бичгүүдийг тухайн хүсэлтийг хүлээн авснаас хойш 10 өдрийн дотор хүргүүлнэ. Хүргүүлж байгаа баримт бичгүүдийн төлбөр тухайн баримт бичгийг хуулбарлахад гарсан зардлаас хэтрэхгүй байна.

4.17. Хэлэлцэх асуудлаар санал хураалтыг саналын хуудсаар явуулна.

4.18. Саналын хуудсыг ХЭХ-д оролцох эрх бүхий этгээдэд ХЭХ-аас 30 дошигүй өдрийн өмнө явуулах буюу хүргэж өгнө.

4.19. Саналын хуудсанд дараах мэдээлэл орно:

4.19.1. Компанийн оноосон нэр болон байршил:

4.19.2. ХЭХ-ийг хуралдуулах хэлбэр:

4.19.3. ХЭХ хуралдах өдөр, газар, цаг болон бөглөсөн саналын хуудсыг эргүүлэн хүргүүлэх шуудангийн хаяг:

4.19.4. Саналын хуудсаар санал өгөх шийдвэрлэх асуудал бүрийн томъёолол (эсвэл нэр дэвшигч бүрийн нэр):

4.19.5. Хэлэлцэх асуудал бүрээр санал өгөх (“зөвшөөрсөн”, “татгалзсан”, “тудгэлзсэн”):

4.19.6. Хэрэв кумулятив аргаар санал хураах бол кумулятив аргыг тайлбарласан холбогдох тэмдэглэл, тайлбар:

4.19.7. Компанийн ТҮЗ-ийн гишүүдийг сонгоход кумулятив аргаар санал хураах бол тухайн саналын хуудсанд нэр дэвшигч бүрийн нэрийн нөгөө талд зай үлдээсэн байх (нэр дэвшигч бүрийн авсан саналын тоог энд бичнэ),

4.19.8. Саналын хуудсанд хувьцаа эзэмшигч заавал гарын үсэг зурна гэсэн тэмдэглэл байх,

4.20. Хэрэв саналыг хувьцаа эзэмшигчийн төлөөлөгч өгч байгаа бол бөглөсөн саналын хуудсыг хувьцаа эзэмшигчийг төлөөлөх эрхийн итгэмжлэлийн хамт компанийд хүргүүлнэ.

ТАВ. ХУВЫЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРАЛ

5.1. Хувыцаа эзэмшигчдийн ээлжит хурал (ХЭЭХ)-аас бусад бүх хурал нь Хувыцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал (ХЭЭБХ) байна.

5.2. ХЭЭБХ-ыг хувыцаа эзэмшигчдийн хурлыг хувыцаа эзэмшигчдийг биечлэн оролцуулах хэлбэрээр зохион байгуулах, хурлаар хэлэлцсэн асуудлаар шийдвэрийг ХЭХ-ын журмын дагуу саналын хуудсыг урьдчилан хургүүлэх эсвэл урьдчилан хургүүлэхгүйгээр авч болох ба эсвэл эчинээ санал (хувыцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулахгүйгээр) хураалт явуулах замаар (саналын хуудсыг ашиглан) явуулж болно.

5.3. ХЭЭБХ-ыг ТУЗ-ийн санаачилгаар зарлан хуралдуулах эсвэл хуульд заасны дагуу зарлан хуралдуулна. Мөн энэхүү журмын 5.4.-д заасан этгээдүүдийн хүсэлтийн дагуу ХЭЭБХ-ыг зарлан хуралдуулахгүй эсвэл хуралдуулахаас татгалзсан нөхцөлд ХЭЭБХ-ыг хуралдуулах хүсэлт гаргасан этгээдүүд ХЭЭБХ-ыг өөрсдөө зарлан хуралдуулж болно.

5.4. ХЭЭБХ-ыг хуралдуулах хүсэлт гаргах эрх бүхий этгээдүүд:

5.4.1. Саналын эрхт бүхий хувыцааны 10-аас доогуй хувийг эзэмшидэг;

5.4.2. ТУЗ-ийн 2 буюу түүнээс дээш тооны хараат бус гишүүд.

5.5. ХЭЭБХ-ын хэлэлцэх асуудалд санал оруулах хувыцаа эзэмшигчийн эзэмшиж байгаа саналын эрх бүхий хувыцааны тоог тухайн хурлыг хуралдуулах хүсэлт гаргасан өдрийн байдлаар тодорхойлно.

5.6. ХЭЭБХ-ыг хуралдуулах хүсэлт нь тухайн хурлаар хэлэлцэх асуудлын томъёоллыг агуулсан байна. Хүсэлтэд мөн хэлэлцэхээр санал болгож байгаа асуудал бүрээр гарах шийдвэрийн томъёоллыг оруулах ба мөн ХЭХ-ын санал болгох хэлбэрээр оруулж болно. Хэрэв гаргаж байгаа хүсэлт нь нэр дэвшүүлэх асуудлыг хөндөж байгаа бол энэхүү журмын гуравдугаар зүйлийн заалт үйлчилнэ.

5.7. ХЭЭБХ-ыг хуралдуулах хүсэлт гаргасан хувыцаа эзэмшигчид нь өөрсдийн нэр, эзэмшиж байгаа хувыцааны тоо, ангилал, төрлийг мэдэгдэнэ.

5.8. ХЭЭБХ-ыг хуралдуулах хүсэлтэд хүсэлт гаргаж байгаа этгээдүүд нь гарын үсэг зурна. Хэрэв хүсэлтэд тухайн хүсэлтийг гаргаж байгаа хувыцаа эзэмшигчдийн төлөөлөгч гарын үсэг зурсан бол тухайн хүсэлтэд холбогдох хуулийн дагуу шаардагдах мэдээлэл бүхий итгэмжлэлийг хавсарган хургүүлнэ.

5.9. ХЭЭБХ-ыг 5.4-д заасны дагуу зарлан хуралдуулж байгаа бол санал болгож байгаа хурлаар хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн томъёолол эсвэл хурлын хэлбэр зэргийг ТУЗ өөрчлөх эрхгүй. Компанийн тухай хуульд болон журамд зааснаас бусад нөхцөлд ХЭЭБХ-ыг зарлан хуралдуулах хүсэлтэд татгалзсан хариу өгөх эрхгүй болно.

5.10. Саналын эрхтэй хувыцааны 10-аас дээш хувийг эзэмшигч хувыцаа эзэмшигчид эсхүл хоёр буюу түүнээс дээш хараат бус гишүүдийн хүсэлтээр ХЭЭБХ-ыг тухайн хүсэлтийг хүлээн авснаас хойш 45 өдрийн дотор зарлан хуралдуулна.

5.11. Хуульд өөрөөр заагаагүй эсвэл энэ журмын 5 дугаар зүйлд өөрөөр заагаагүй бол, ХЭЭБХ-ыг зарлах болон бэлтгэлийг хангах асуудлыг энэхүү журмын зүйл 3 болон 4-д заасны дагуу зохицуулна.

ЗУРГАА. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД БИЕЧЛЭН ОРОЛЦОХ ХЭЛБЭРЭЭР ХЭХ-ЫГ ЗАРЛАН ХУРАЛДУУЛАХ

6.1. Хувьцаа эзэмшигчдийн хуралд хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтад орсон болон эдгээр хүмүүсийн эрхийн итгэмжлэлээр эсвэл Хуулийн дагуу төлөөлөх хүмүүс оролцох эрхтэй.

6.2. ХЭХ-д оролцох эрх бүхий хүмүүсийг ХЭХ хуралдах өдөр бүртгэнэ. Бүртгэл ХЭХ эхлэхээс өмнө нэг цагаас доошгүй хугацаанд эхэлнэ.

6.3. ХЭХ-д оролцогсдын бүртгэлийг ХЭХ хуралдах байранд хийнэ.

6.4. Зөвхөн хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтад орсон хүмүүс иргэний үнэмлэхээ үзүүлэн ХЭХ-д оролцооор бүртгүүлж болно.

6.5. ХЭХ-д оролцох эрх бүхий хүмүүсийн иргэний үнэмлэхийг нь хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт дахь өгөгдлүүдтэй тулган үзэж бүртгэнэ.

6.6. Тооллогын комиссын ажлыг хөндлөнгийн байгууллагаар гүйцэтгүүлж болно.

6.7. ХЭХ-д оролцооор бүртгэгдсэн хувьцаа эзэмшигчид (эсвэл тэдний төлөөлөл) болон компани саналын хуудсыг нь хүлээн авсан хувьцаа эзэмшигчдийг (тэдний төлөөлөл) ХЭХ-д оролцсон гэж үзнэ.

6.8. Дараах хүмүүс ХЭХ-д оролцоно:

6.8.1. Хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтад орсон хүмүүс болон тэдний эрх бүхий төлөөлөл,

6.8.2. Гүйцэтгэх удирдлагын багийн гишүүд, гүйцэтгэх захирлууд, хөндлөнгийн аудитор,

6.8.3. ТУЗ-ийн гишүүд,

6.8.4. Тооллогын комиссын гишүүд,

6.8.5. Компанийн удирдлагад нэр дэвшиж байгаа саналын хуудсанд бичигдсэн хүмүүс,

6.8.6. ТУЗ-ийн дарга болон гүйцэтгэх захирлын урьсан хүмүүс.

6.9. Энэ журмын 6.9.5. болон 6.9.6.-д заасан хүмүүс зөвхөн ХЭХ-ын даргын зөвшөөрлөөр ХЭХ-д оролцоно.

6.10. Хувьцаа эзэмшигч нь өөрийн төлөөллийг солих эсвэл өөрөө ХЭХ-д биечлэн оролцох эрхтэй бөгөөд тэгэхдээ тооллогын комисс буюу компанийд ХЭХ эхлэхээс өмнө төлөөлөн оролцох хүнд олгосон итгэмжлэлийг хүчингүй болгох (эсвэл солих талаар) бичгээр мэдэгдэнэ.

6.11. Компанийн саналын эрх бүхий хувьцааны 50-аас дээш хувийг эзэмшигчид ХЭХ-д оролцсоноор тухайн хурал хүчин төгөлдөр болно.

6.12. Хэлэлцэх бүх асуудлаар ХЭХ-ыг эхлэх үед ирц (кворум) бүрэлдээгүй бол ХЭХ-ыг нээн хуралдуулах хугацааг 19 өдрөөр хойшлуулна.

6.13. ХЭХ-ын хэлэлцэх асуудалд хувьцаа эзэмшигчдийн янз бүрийн бүлгүүд (энгийн, давуу эрхийн хувьцаа эзэмшигч) санал өгөх байвал тухайн хэлэлцэх асуудал бүрт ногдох квормыг тухайн асуудлыг хэлэлцэж эхлэхээс өмнө жич тогтооно.

6.14. Ирц бүрдээгүйгээс ХЭХ-ын товыг дахин товлох тохиолдолд хэлэлцэх асуудалд өөрчлөлт орохгүй.

6.15. ХЭХ-ын өдрийг дахин товлох шийдвэрийг ХЭХ-ийг анх хуралдуулах шийдвэр гаргасан этгээд гаргана.

6.16. ХЭХ-ыг компанийн байранд эсвэл дийлэнх хувьцаа эзэмшигчдийн хувьд очиход төвөггүй өөр газар хуралдуулна.

6.17. ХЭХ-ыг шөнийн цагаар хуралдуулж болохгүй.

6.18. ХЭХ нэг өдөрт багтахгүй бол ХЭХ-ыг дарга дараа өдрийн өглөө хүртэл хурлыг завсарлуулна.

6.19. ХЭХ-ын дарга нь ХЭХ-д хэлэлцэх асуудлын дагуу тавигдах илтгэлүүдийн дарааллыг тогтоох ба ХЭХ-ын тэмдэглэлд \протокол\ гарын үсэг зурна.

6.20. ХЭХ-ын дарга нь ТУЗ-ийн дарга байх бөгөөд түүний эзгүйд ТУЗ-өөс томилсон ТУЗ-ийн аль нэг гишүүн даргална.

6.21. ХЭЭБХ-ыг хуралдуулахыг ТУЗ татгалзсан тохиолдолд, ХЭЭБХ-ыг хуралдуулахаар зарласан хүн ХЭЭБХ-ын даргыг томилох эрхтэй.

6.22. ХЭХ-ын эхэнд, Тооллогын комиссын дарга ХЭХ-ын ирцийг мэдээлж, ХЭХ-аар хэлэлцэх асуудал бүрээр хэрхэн санал өгөх талаар тайлбарлана.

6.23. ХЭХ-ын эхэнд, хурлын дарга ХЭХ-д оролцож байгаа ТУЗ-ийн гишүүн гүйцэтгэх удирдлагын жагсаалтыг уншиж танилцуулах ба хэлэлцүүлэгт оролцох журам, илтгэл тавих, асуулт асуулж, хариулт өгөх болон ХЭХ-ыг явуулах журмын бусад матеріалыг нарийвчлан тайлбарлана.

6.24. ХЭХ-ын дарга хувьцаа эзэмшигчдэд одоогийн ТУЗ болон ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчид Компанийн тухай хуулийн заалтын дагуу хараат бус байх шалгуурыг хангаж байгаа эсэх талаар мэдээлэл хийнэ.

6.25. ХЭХ-ын ажиллагаа тасралтгүй явагдана. ХЭХ-ын дарга хурлыг 2 цаг тутам 20 хүртэл минутаар завсарлуулна.

6.26. Санал хураах асуудал бүрээр үг хэлэх хүн бүрт 4 минутын хугацаа олгоно (тухайн асуудлаар шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллийг танилцуулахад хүрэлцээтэй хугацаа)

6.27. ХЭХ-ын бүх оролцогод санал хураах хэлэлцэх асуудлаар санал бодлоо илэрхийлэхэд нь 4 минут өгнө.

6.28. ХЭХ-ын дарга нь хэлэлцэх асуудлаар явагдах хэлэлцүүлгийн үр дүнтэй байх нөхцөлийг хангаж, санал хураахгүй асуудлаар хэлэлцүүлэг өрнүүлэхгүй байна.

6.29. Хэлэлцэх асуудлын сүүлийн асуудлыг хэлэлцэж дууссаны дараа, ХЭХ-ын дарга гарах шийдвэр болон санал хураалтын дунг мэдээлэх журмын талаар хувьцаа эзэмшигчдэд тайлбарлана.

6.30. ХЭХ дээр санал өгөхдөө нэг хувьцаа нэг санал гэсэн зарчмыг баримтлах ба харин кумулятив аргаар санал хураахад энэ зарчим хамаarahгүй.

6.31. Санал авах хуудсанд ХЭХ-аар хэлэлцэх асуудал бүрээр нэг санал өгөх хувилбараар тэмдэглэл хийгдэнэ. Энэ журмыг зөрчиж тэмдэглэл хийгдсэн саналын хуудас тухайн буруу тэмдэглэл хийгдсэн асуудлын хувьд хүчингүйд тооцно.

6.32. Нэг эсвэл хэд хэдэн асуудлаар буруу тэмдэглэл хийгдсэн саналын хуудас нь бүхэлдээ хүчингүйд тооцогдохгүй.

6.33. Хуульд өөрөөр заагаагүй эсвэл тодорхой нөхцөл байдалд ХЭЭБХ хуралдаагүй бол, ХЭЭБХ-ыг зарлан хуралдуулах, бэлтгэлийг хангах журмыг энэхүү журмын 5 болон 6 дугаар зүйлээр зохицуулна.

ДОЛОО. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫГ ЭЧНЭЭ САНАЛ ХУРААЛТААР ЯВУУЛАХ

7.1. ХЭХ-ын шийдвэрийг хурлыг хуралдуулахгүйгээр эчнээ санал хураалтаар гаргаж болно.

7.2. ХЭЭХ болон дахин товлогдсон ХЭЭХ-ыг эчнээ санал хураалтын хэлбэрээр явуулахгүй.

7.3. Хувьцаа эзэмшигчдийн бөглөж тэмдэглэл хийсэн саналын хуудсыг товлосон хугацаа дусахаас өмнө ирүүлсэн хувьцаа эзэмшигчийг ХЭХ-д оролцсоноор тооцно.

НАЙМ. ШИЙДВЭР ГАРГАХ ЖУРАМ БА БАРИМТ БИЧГИЙН ХӨТЛӨЛТ

8.1. Дараах асуудлаар шийдвэрийг ХЭХ-д оролцогсдын 3\4-дийлэнх олонхын саналаар гаргана.

8.1.1. Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах болон шинэчилсэн найруулгыг батлах,

8.1.2. Компанийг өөрчлөн байгуулах,

8.1.3. Компанийг татан буулгах ба татан буулгах комиссыг томилох,

8.1.4. Компанийн хэлбэрийг өөрчлөх,

8.1.5. Нэмэлт хувьцаа гаргах, гаргах хувьцааны тоог тогтоох, компанийн өрийг хувьцаагаар солих,

8.1.6. Компанийн хувьцааг хуваах болон нэгтгэх.

8.2. Давуу эрхийн хувьцаа эзэмшигчдийн эрхийг хязгаарлахтай холбогдсон нэмэлт өөрчлөлтийг компанийн дүрэмд оруулах эсвэл компанийн шинэ дүрэмд баримталж эхлэхтэй холбогдсон шийдвэрт дараах байдлаар санал өгсөн бол шийдвэр гарсанд тооцно.

8.2.1. ХЭХ-д саналын эрх бүхий хувьцаа эзэмшигчдийн дийлэнх олонх (З\4-аас цөөнгүй хувь нь оролцож санал өгсөн байх ба үүнд эрхээ хязгаарлуулж байгаа давуу эрх бүхий хувьцаа эзэмшигчдийн саналыг оролцуулахгүй),

8.2.2. Эрх нь хязгаарлагдах гэж байгаа давуу эрх бүхий хувьцаа эзэмшигчдийн энгийн олонхын саналаар шийдвэр гаргана.

8.3. Бусад бүх асуудлаар ХЭХ-д оролцож саналын эрх бүхий хувьцаа эзэмшигчдийн энгийн олонхын саналаар шийдвэр гаргана.

8.4. ХЭХ-ын тооллогын комиссын тогтоол болон санал хураалтын дүнгийн тухай тайланг ХЭХ-ын дараа бэлтгэн гаргана. ХЭХ-ын тэмдэглэлийг хурлаас хойш ажлын З өдрийн дотор бэлэн болгоно.

8.5. Тооллогын комисс нь санал хураалтын хураангуй дүн болон дүнгийн тогтоолыг ХЭХ дууссанаас хойш ажлын З өдрийн дотор бэлэн болгоно. Санал хураалтын дүнгийн тухай тооллогын комиссын тогтоолд тооллогын комиссын дарга болон гишүүд гарын үсэг зурна.

8.6. ХЭХ-ын тэмдэглэлийг ХЭХ-ын нарийн бичгийн дарга хурал дууссанаас хойш ажлын З өдрийн дотор хоёр хувь үйлдэнэ. Хоёр хувь дээр хурлын дарга гарын үсэг зурна. Тооллогын комиссын бэлтгэсэн санал хураалтын дүнгийн тухай тогтоолыг ХЭХ-ын тэмдэглэлд хавсаргана.

8.7. ХЭХ-ын тэмдэглэлд дараах мэдээллийг тусгана:

8.7.1. Компанийн хууль ёсны нэр ба хаяг,

8.7.2. ХЭХ-ын төрөл (ХЭЭХ эсвэл ХЭЭБХ),

8.7.3. ХЭХ-ын хэлбэр,

8.7.4. ХЭХ-ын огноо болон хугацаа,

8.7.5. ХЭХ хуралдсан газар,

8.7.6. ХЭХ-ын хэлэлцээн асуудал,

8.7.7. Саналын хуудсыг бөглөж, компанид ирүүлэх шуудангийн хаяг хэрэв тийнхүү ирүүлж болохоор заасан байвал,

8.7.8. Хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтад орсон хүмүүсийн саналын тоо нь хэлэлцэх асуудал бүрт хамаарна,

8.7.9. ХЭХ-д биечлэн оролцож байгаа хүмүүсийн саналын тоо нь хэлэлцэх асуудал бүрт хамаартна,

8.7.10. Ирц бүрдсэн нөхцөлд өгсөн санал бүр нь тухайн асуудлын хувьд (“зөвшөөрсөн”, “татгалзсан”, “түдгэлзсэн”) хүчин төгөлдөр байна.

8.7.11. ХЭХ-аас хэлэлцээн асуудал бүрээр гаргасан шийдвэрийн томъёолол,

8.7.12. ХЭХ-ын дарга, нарийн бичгийн даргын нэрс,

8.7.13. ХЭХ-ын тэмдэглэл (протокол) үйлдсэн огноо,

8.7.14. ХЭХ-ын шийдвэр.

8.8. ХЭХ-ын тэмдэглэлд бичсэн ХЭХ-ын асуудал бүрээр гаргасан шийдвэрийн томъёолол нь саналын хуудсанд бичигдсэн тухайн шийдвэрийн томъёоллоос өөр байж үл болно.

8.9. ХЭХ-ын тэмдэглэлд гарын үсэг зурагсаны дараа, тооллогын комисс саналын хуудсуудыг лацдаж, компанийн архивт хадгална.

8.10. Тооллогын комиссын ХЭХ-ын санал хураалтын дүнгийн тухай илтгэлд дараах мэдээллийг тусгана:

8.10.1. Компанийн оноосон бүтэн нэр, хаяг,

8.10.2. ХЭХ-ын төрөл \ХЭЭХ эсвэл ХЭЭБХ\ болон хуралдуулсан хэлбэр,

8.10.3. ХЭХ-ын хуралдсан өдөр, байршил, бөглөсөн саналын хуудсыг буцаан хүргүүлсэн шуудангийн хаяг, хэрэв ХЭХ-ыг энээс хэлбэрээр хуралдуулсан бол саналын хуудсыг эргүүлэн хүлээн авах сүүлийн хугацаа, бөглөсөн саналын хуудсыг эргүүлэн хүргүүлсэн шуудангийн хаяг,

8.10.4. ХЭХ-ын хэлэлцсэн асуудал,

8.10.5. ХЭХ-аар шийдвэрлэсэн асуудлууд, тухайн асуудлуудаар товлосон хугацаанд саналын хуудсаа ирүүлсэн хувьцаа эзэмшигчдийн нэрсний жагсаалт болон тэдгээр хувьцаа эзэмшигчдийн эзэмшиж байгаа хувьцааны тоо,

8.10.6. Хэлэлцсэн асуудал бүрээр хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтад бүртгэгдсэн хүмүүсээс ирүүлээгүй саналын тоо,

8.10.7. Хэлэлцсэн асуудлаар ирц бүрдсэн эсэх тухай мэдээлэл,

8.10.8. Ирц бүрдсэн нөхцөлд хэлэлцсэн асуудал бүрээр өгсөн саналын тоо (“зөвшөөрсөн”, “татгалзсан”, “түдгэлзсэн”),

8.10.9. ХЭХ-аар хэлэлцсэн асуудал бүрээр өгсөн саналын хүчингүй болсон саналын хуудасны тоо,

8.10.10. Хурлаар хэлэлцсэн асуудал бүрээр гаргасан шийдвэрийн томъёолол,

8.10.11. Тооллогын комиссын үүргийг гүйцэтгэсэн хөндлөнгийн байгууллагын нэр, хаяг, тухайн байгууллагаас ХЭХ-ын Тооллогын комиссын ажлыг эрхлэн гүйцэтгэх эрх олгосон хүмүүсийн нэр,

8.10.12. ХЭХ-ын дарга, нарийн бичгийн даргын нэр,

8.10.13. Тооллогын комиссын дарга болон гишүүдийн гарын үсэг,

8.10.14. Санал хураалтын дүнгийн тайланг бичсэн огноо,

8.11. ХЭХ-ын санал хураалтын тухай тайланд ХЭХ-ын дарга, нарийн бичгийн дарга нар гарын үсэг зурна.

8.12. ХЭХ-ын хэлэлцэх асуудалд нэгдмэл сонирхолтой талуудын хэлцэлтэй холбогдсон асуудал орсон бол ХЭХ-ын тэмдэглэл, тооллогын комиссын тэмдэглэл, санал хураалтын дүнгийн тухай тайланд тухайн асуудлаар дараах мэдээллийг оруулна.

8.12.1. Хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтад орсон, тухайн хэлцлийн хувьд нэгдмэл сонирхолгүй хүмүүсийн саналын тоо,

8.12.2. ХЭХ-д биечлэн оролцсон, тухайн хэлцлийн хувьд нэгдмэл сонирхолгүй хүмүүсийн саналын тоо,

8.12.3. Ангилал бүрээр өгсөн саналын тоо (“зөвшөөрсөн”, “татгалзсан”, “түдгэлзсэн”)

8.13. ХЭХ-ын хэлэлцэх асуудалд давуу эрхийн аль нэг төрлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хязгаарлах нэмэлт өөрчлөлтийг компанийн дүрэмд оруулах (шинэчлэн найруулсан дүрмийг батлах) эсвэл компанийн дүрэмд оруулах нэмэлт өөрчлөлт нь хуулийн дагуу давуу эрхийн аль нэг төрлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хязгаарлах асуудал орсон бол ХЭХ-ын тэмдэглэл, тооллогын комиссын тэмдэглэлд тухайн асуудлаар дараах мэдээллийг оруулна.

8.13.1. Эрх нь хязгаарлагдаж болох давуу эрхийн хувьцаа эзэмшигчдийн саналын тоог оролцуулахгүйгээр хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтад бүртгэгдсэн хүмүүсийн саналын тоо,

8.13.2. Эрх нь хязгаарлагдаж болох давуу эрхийн хувьцаа эзэмшигчдийн саналын тоо,

8.13.3. ХЭХ-д биечлэн оролцсон хувьцаа эзэмшигчдийн саналын тоо, үүнд эрх нь хязгаарлагдаж болох давуу эрхийн хувьцаа эзэмшигчдийн саналын тоо орохгүй ба тэдгээр давуу эрхийн хувьцаа эзэмшигчдийн саналын тоог жичид нь гаргах,

8.13.4. Хэлэлцсэн асуудлаар өгсөн саналын ангилал бүрийн тоо (“зөвшөөрсөн”, “татгалзсан”, “түдгэлзсэн”), үүнд эрх нь хязгаарлагдаж болох давуу эрхийн хувьцаа эзэмшигчдийн өгсөн саналын ангилал бүрийн (“зөвшөөрсөн”, “татгалзсан”, “түдгэлзсэн”) тоог жичид нь гаргах,

8.14. ХЭХ-аас гаргасан шийдвэр болон санал хураалтын дүнг ХЭХ дээр зарлан мэдэгдэх эсвэл хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтад орсон хүмүүст санал хураалтын дүнгийн илтгэлийг ТУЗ хүлээн авсанаас хойш ажлын долоо хоногт багтаан хувьцаа эзэмшигчдийн бүртгэлд байгаар баталгаат шуудангаар хүргүүлнэ.